



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2019 оны 05 сарын 21 өдөр

Дугаар 206

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад  
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 86 дугаар тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Хөдөө аж ахуйн бирж” ХХК-ийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 14 нэр төрлийн, нийт 18,134,925.00 (арван найман сая нэг зуун гучин дөрвөн мянга есөн зуун хорин таван) төгрөгийн балансын үнэ, 9,484,377.28 (есөн сая дөрвөн зуун наян дөрвөн мянга гурван зуун далан долоон төгрөг хорин найман мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан үндсэн хөрөнгийг Шинжлэх Ухааны Академид балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Баярсайхан, “Хөдөө аж ахуйн бирж” ХХК-ийн гүйцэтгэх захирал Х.Баатар, Шинжлэх Ухааны Академийн ерөнхийлөгч Д.Рэгдэл нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;


2.3. Арга хэмжээний биелэлтийг 2019 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.


ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

  
Б.ГАНБАТ

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА

  
А.АРИУНБОЛД





Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2019 оны 05 дугаар сарын 2-ны өдрийн  
206 дугаар тогтоолын хавсрагт

"Хөдөө аж ахуйн бирж" ХХК-ийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй,  
Шинжлэх ухааны академид балансаас балансад шилжүүлэх эд хөрөнгийн жагсаалт

Д/д	Хөрөнгийн нэр, марк	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Ашиглалтад орсон он	Балансын		Хуримтлагдсан эзлэгдэл	Үлдэгдэл өртөг
					Нэг бүрийн үнэ	Нийт үнэ		
1	Ширээ/нарийн сургалтын /	ш	8	2014/04/29	145,200.00	1,161,600.00	570,722.20	590,877.80
2	Ширээ/нарийн сургалтын /	ш	6	2014/04/29	137,500.00	825,000.00	405,342.47	419,657.53
3	Ширээ /WAL1200/	ш	3	2013/03/01	154,990.00	464,970.00	282,697.59	182,272.41
4	Ширээ /WV 1410 L,R /	ш	1	2014/04/11	392,700.00	392,700.00	196,215.51	196,484.49
5	Ширээ /хурлын 3015/	ш	1	2014/04/29	4,335,500.00	4,335,500.00	2,130,136.08	2,205,363.92
6	Ширээ /хурлын 1575/	ш	2	2014/04/29	1,127,500.00	2,255,000.00	1,107,936.08	1,147,063.92
7	Ширээ /хурлын/	ш	1	2013/03/01	459,690.00	459,690.00	279,487.82	180,202.18
8	Тумбочка /AL3DH/	ш	2	2013/03/01	201,190.00	402,380.00	241,290.20	161,089.81
9	Тумбочка /MP2D дугуйтай/	ш	1	2014/04/11	256,390.00	256,390.00	128,062.23	128,327.77
10	Сандал /чарган DM-309/	ш	5	2013/03/01	127,490.00	637,450.00	387,563.66	249,886.34
11	Сандал / DM-309/	ш	1	2013/03/19	151,690.00	151,690.00	90,962.03	60,727.97
12	Сандал /хурлын торон/	ш	15	2014/04/29	227,700.00	3,415,500.00	1,678,117.82	1,737,382.18
13	Сандал /98H228/	ш	15	2014/04/29	38,500.00	577,500.00	283,739.72	293,760.28
14	Сандал /Уулзалт/харN504/	ш	19	2013/03/14	147,345.00	2,799,555.00	1,702,103.89	1,097,451.12
					<b>18,134,925.00</b>		<b>9,484,377.28</b>	<b>8,650,547.72</b>
					(арван найман сая нэг зуун гучин дөрвөн мянга есөн зуун хорин таван)		(есөн сая дөрвөн зуун наян дөрвөн мянга гурван зуун далан долоон төгрөг хорин найман мөнгө)	(найман сая зургаан зуун тавин мянга таван зуун дөчин долоон төгрөг далан хоёр мөнгө)
Нийт дүн					ш	80		